



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАТШИРЭЭТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 06 сарын 02 өдөр

Дугаар А/109

Батширээт сум


Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан "Эхийн алдар" одонгоор шагнагдсан эхчүүдийг хүлээн авч хүндэтгэл үзүүлэх зардалд 530,100 (таван зуун гучин мянга нэг зуун) төгрөг, сонгогдсон 20 өрхийн хүүхдүүдэд баярын бэлэг гардуулах зардалд 1,000,000 (нэг сая) төгрөг, төгсөлтийн баяр тэмдэглэж буй Сургуулийн өмнөх боловсролын газар болон Ерөнхий боловсролын сургуулийн нийт 4 багш нарын урамшуулалд 200,000 (хоёр зуун мянган) төгрөг, нийт 1,730,100 зарцуулсугай.

2. Дээрх зардлыг Засаг даргын нөөц сангаас зарцуулахыг нягтлан бодогч (Б.Цолмон)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



БАЛТАНГЭРЭЛ

2025.06.02